

ГАДААДЫН ЗЭЭЛ ТУСЛАМЖААР ХЭРЭГГИЖ БУЙ ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨР ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТ

#	Төслийн нэр	Зорилтот сум/бүлэг	Төсөл хэрэгжүүлэгч	Хэрэгжүүлэх хугацаа үе шат	Төсөв	Санхүүжүүлэгч	Төслийн тодорхойлолт	Төслийн хэрэгжилтийн явц
1	Нийгмийн эгэх хариуцлагыг бэхжүүлэх нь төсөл	Өвөрхангай аймгийн Бүрд, Есөнзүйл, Өлзийт, Баянгол, Төгрөг, Гучин ус, Богд, Нарийнтээл, Хайрхандулаан, Тарагт 10 сум	Засаг даргын тамгын газар нийгмийн хөгжлийн хэлтэс	2015-2019	80,000,000 MNT	Швейцарийн Хөгжлийн агентлаг Дэлхийн банк	Нийгмийн эгэх хариуцлагын дэмжлэгтэйгээр орон нутгийн ядуурлыг бууруулах, орон нутгийн иргэд төрийн шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцох, чанартай үйлчилгээг хүртэх боломжоор хангагдахад оршино.	Хэрэгжиж байгаа
үр дүн	<b>Гарсан үр дүн:</b> Өвөрхангай аймгийн Бүрд, Есөнзүйл, Өлзийт, Баянгол, Төгрөг, Гучин ус, Богд, Нарийнтээл, Хайрхандулаан, Тарагт сумын Ерөнхий боловсролын сургуулиудад "Олон нийтийн оролцоот сургууль" дэд төслийг хэрэгжүүлэн сургуулийн аливаа мэдээллүүд нээлттэй, ил тод болж сургууль болон эцэг эхчүүдийн хамтын ажиллагаа сайжирч байна.							
2	Малын эзэмгний дугаар, мал бүртгэлийн системийг сайжруулах, Пилот төсөл	Баянгол, Гучин-Ус, Зүүнбаян-Улаан	Өвөрхангай аймгийн ХХАА газар	2017-2020	Тодорхой бус	Франц улс	Малыг ялган тэмдэглэх, бүртгэлжүүлэх, малын эзэмгний дугаар, мал бүртгэлийн системийг сайжруулах.	Хэрэгжиж байгаа
үр дүн	<b>Гарах үр дүн:</b> Баянгол, Гучин-Ус, Зүүнбаян-Улаан сумдын малыг ялган тэмдэглэх, бүртгэлжүүлэх, малын эзэмгний дугаар, мал бүртгэлийн системийг сайжруулна.							
3	Ногоон алт хөтөлбөр	Уянга, Бат-өлзий, Богд, Зүүнбаян-Улаан	Сарлаг-Эрдэнэ ТББ Аймгийн Хүнс Хөдөө Аж Ахуйн газар	2016-2019	70,000,000 MNT 2017-2018 оны төсөв	Швейцарийн Хөгжлийн агентлаг	Ногоон алт" төсөл орлогыг нэмэгдүүлэхийн тулд бүтээмжийг дээшлүүлэхийн зэрэгцээ бэлчээрийн экологийн хязгаарлалтыг тэнцвэрт байдалд оруулан бэлчээрийг сэргээх малчдын амьжиргааны түвшний тогтвортой, уян хатан байдлыг хангах нөхцөл, чадавхийг Монголын иргэдэд бий болгохыг зорьж байгаа юм.	Хэрэгжиж байгаа
үр дүн	<b>Гарах үр дүн</b> 1: Зорилтот сумын малчид 25-50 сая төгрөгний дундын сантай болно. 2: Бэлчээрийн талхлалтыг бууруулах зорилгоор малчин өрх бүр газраа гэрээгээр эзэмших, малаа чанаржуулах эрүүлжүүлэх ажлыг хийнэ. 3: Малчдын үйлдвэрлэж байгаа бүтээгдэхүүн түүхий эдийн үнэлэмжийг дээшлүүлэх, зах зээлд борлуулж өгөх. 4: 6 сар хүртэл хугацаатай 5 сая хүртэл төгрөгийн бичил төслийг санхүүжүүлнэ.							
4	Агро бизнесийг хөгжүүлэх төсөл	Арвайхээр сум, Төгрөг сум, Тарагт сум	Бизнесийн шинэ санаа нэвтрүүлэх төв ТББ Такикава клуб Аймгийн Хүнс Хөдөө Аж Ахуйн газар	2017-2020	48,600,000 MNT Одоогийн байдлаар	Жайка Олон Улсын байгууллаг	1. Газар тариалан эрхлэгчдийн орлогыг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн агробизнесийг хөгжүүлэх төсөл" 2. Бөөрөнхий сонгиныг үрслэгээр суулгаж тарих. Энэ нь 2 жилд ургадаг сонгины үрийг нэг жилд тарьж ургац авах.	Хэрэгжиж байгаа
үр дүн	<b>Гарсан үр дүн:</b> Одоогийн байдлаар 48,6 сая төгрөгийн санхүүжилтээр Арвайхээр суманд Нарлаг хүлэмж 2 ш, худаг 1 ш, Төгрөг, Тарагт суманд нийлэг хүлэмж, үр бордоогоор хангагдаад байна.							
5	Гамшгийн эрсдлийг бууруулахад уламжлалт болон шинжлэх ухааны аргыг ашиглах нь төсөл	Өвөрхангай аймгийн Зүүнбаян-Улаан, Бат-Өлзий, Уянга, Нарийнтээл, Хужирт, Хархорин, Баян-Өндөр, Зүйл, Бүрд, Өлзийт 10 сумын малчид мал эмнэлэг	Mercury corps	2016-2017	100,000,000 MNT	АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлаг	Шаардагдах цаг агаарын мэдээллийг түгээж орон нутагт гамшгийн төлөвлөлт болон эрсдлийг бууруулах чадавхийг сайжруулснаар малчид болон хөдөөгийн эдийн засагт тохиох зудын эрсдлийг бууруулах.	Хэрэгжиж байгаа

үр дүн	<b>Гарах үр дүн:</b> 1: Зорилтод сумдын малчид тухайн орон нутгийнхаа цаг агаарын мэдээллийг гар утсаараа буюу мессежээр хүлээн авдаг болсон байна. 2: Гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлийн мэдлэг олгох сургалтын хөтөлбөр модулийг шинэчилэнэ. 3: Сумын гамшгийн төлөвлөгөөг иргэдийн оролцоотойгоор боловсруулдаг болсон байна.4: Зудын эрсдлийг бууруулах зорилгоор 7 сумын МЭУНэгжид бог малын зөөврийн хашаа, 3 сумын МЭУНэгжид лабораторийн тоног төхөөрөмжийг өгнө							
6	Дасан зохицох даван туулах чадвартай орон нутгийн иргэд хөтөлбөр	Өвөрхангай аймгийн малчид, мах болвсруулах үйлдвэрүүд, малын тэжээл үйлдвэрлэгчид, мал эмнэлэг, жижиг дунд бизнес эрхлэгчид, төрийн албан хаагчид	Mercury corps	2016-2019	Тодорхой бус	Mercury corps өөрийн санхүүжилтээр	Өрсөлдөх, даван туулж дасан зохицох чадвартай мал аж ахуйн салбар нь монголын хот хөдөөгийн иргэдийн орлого, сайн сайхныг дээшлүүлж, залуучуудын ажил эрхлэлтийг дэмжинэ	Хэрэгжиж байгаа
үр дүн	Энэ төслийн бичиг баримтыг дахин шинээр боловсруулж байгаа тул хүрэх үр дүнг одоогоор сайн тодорхойлоогүй байна. 7 сард гарна							
7	Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төсөл	Хархорин сум орхоны хөндий	Хархорин сум Орхоны Хөндийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа	2015-05-01 2020-05-01	6,650,000,000.00 MNT, 11,500,000.00 EUR	ХБНГУ-ын Сэргээн босголтын хөгжлийн банк Монгол Улсын Засгийн Газар	Монгол орны тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийг (орчны бүс болон экологийн коридор) бэхжүүлэх, биологийн олон янз байдлыг хамгаалах, орчны бүс дэх орон нутгийн ард иргэдийн тогтвортой амьжиргааг дэмжихэд оршино.	Хэрэгжиж байгаа
үр дүн	<b>Гарах үр дүн:</b> 1: Тусгай хамгаалалттай газрууд болон тэдгээрийн орчны бүсийн менежментийн төлөвлөгөөг сайжруулсан байна, төслийн эхний шатны бэлтгэл хангагдсан байна, 2: Тусгай хамгаалалттай газруудын батлагдсан менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлсэн байна, 3: Үндэсний болон бүсийн түвшинд Тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг бэхжүүлэх, 4: Сургалт, бодлого, судалгааны хамтын ажиллагаа сайжирсан байна							
8	"Алслагдсан хөдөөгийн малчдын хүүхдүүдийн бага боловсролын үр дүнг сайжруулах нь" төсөл	Өвөрхангай аймагийн аймгийн Баянгол, Баян-Өндөр, Богд, Бүрд, Есөнзүйл, Зүүнбаян-Улаан, Сант, Тарагт, Уянга, Хайрхандулаан 10 сум	Японы хүүхдийг ивээх сан	2012-2017	2,500,000 USD	Дэлхийн банк болон Японы Нийгмийн хөгжлийн сан	Төслийн зорилго: Боловсролын хамрагдалт, хүртээмж доогуур байгаа Архангай, Өвөрхангай, Дорнод, Сүхбаатар аймгийн 30 сумын малчин өрхийн 5-10 насны 7,500 орчим хүүхдийн боловсролын хүртээмж, чанар, үр ашгийг нэмэгдүүлнэ.	Хэрэгжиж байгаа
үр дүн	<b>Гарсан үр дүн:</b> 2013-2014 оны хичээлийн жилээс эхлэн 2016-2017 оны хичээлийн жил хүртэл аймгийн хэмжээнд нийт 3,270 /1580 эм/ хүүхэд үүнээс 1,584 / 768 эм/ хүүхэд гэр бүлийн орчинд сургуульд бэлтгэх хөтөлбөрт, 1629 /798 эм/ хүүхэд Хичээлийн бус цагийн нэмэлт хөтөлбөрт, 64 /22 эм/ хүүхэд Бага боловсрол нөхөн олгох хөтөлбөрт тус тус хамрагдан төслийн үр шимийг шууд үзэв.Мөн зорилтот хүүхдүүдийн 6,540 эцэг эх, 305 бага ангийн багш, дотуур байрын багш, нийгмийн ажилтан, СӨБ-ийн эрхлэгч, багш, 41 насан туршийн боловсролын төв, нэгжийн мэргэжилтнүүд, 58 багийн Засаг дарга, 44 багийн эмч болон бусад албан хаагчид төслийн үр шимийг шууд хүртсэн байна.							
9	Чадваржсан иргэд тогтворжсон амжиргаа төсөл	Арвайхээр, Бат-өлзий, Бүрд, хархорин, Хужирт	Монголын хоршооллын сургалт мэдээллийн төв	2016-2019	970.000 EUR	Европын холбоо Чехийн хөгжлийн агентлаг	Төслийн зорилго нь хоршоод, бичил, жижиг бизнес эрхлэгчдийг чадавжуулах, тэдгээрийн хөгжлийг дэмжих замаар орлого ашгийг нь нэмэгдүүлэхэд оршино.	хэрэгжиж байгаа
үр дүн	<b>Гарсан үр дүн:</b> 1. Өвөрхангай аймгийн Бат-Өлзий, Хархорин, Хужирт, Бүрд, Арвайхээр суманд 22 хоршоо 5 бичил, жижиг үйлдвэрлэл эрхлэгчдийн бизнесийн төслөө санаачлах, боловсруулах, төлөвлөх, санхүүжилт авах арга зүйн сургалтанд хамрагдсан.							
10	Тогтвортой амжиргаа 3	Өвөрхангай аймгийн 19 сум	Сангийн яам	2015-2019	36,200,000.00 USD	Дэлхийн банк Швейцарийн Засгийн газар	Монголын хөдөө орон нутагт тэргүүлэх ач холбогдол бүхий хөрөнгө оруулалтыг төлөвлөх, хэрэгжүүлэх, түүнд засаглал болон иргэд, олон нийтийн оролцоог сайжруулах	Хэрэгжиж байгаа
үр дүн	<b>Гарах үр дүн:</b> Сумын түвшинд: - ОНХС болон ТСУ-н дүрэм журмын хэрэгжилт үр дүнтэй болж, албан ёсны тайлагналт сайжирна; - ОНХС болон ТСУ-ын үе шатуудын талаарх ойлголт нэмэгдэнэ; - Төсөв төлөвлөлт, ХАА, олон нийтийн оролцоо болон Бэлчээрийн менежментийн талаарх мэдлэг, үр чадвар дээшилнэ; - Туршлага судалж, мэдээлэл солилцох арга барил сайжирна; - ОНХС-н хэрэгжүүлэхэд илт хүндэрлэтэй байгаа сумдыг бодлогын түвшинд асуудал болгож тодорхойлно. Аймгийн түвшинд: - СДБ болон аймгийн ЗДТГ-ын албан хаагчдын мэдлэг үр чадвар дээшилж, сумдад үзүүлэх дэмжлэг туслалцаа сайжирна.							
11	Тогтвортой хөгжилийн боловсрол төсөл	Өвөрхангай аймгийн зорилтот 15 сургууль 12 сум	Сургалт мэдээллийн Онги ТББ	2016-2019	Тодорхой бус	Швейцарийн Хөгжлийн агентлаг	Үр чадварыг сайжруулах сургалт	Хэрэгжиж байгаа
үр дүн	<b>Гарсан үр дүн:</b> 1. Өвөрхангай аймгийн зорилтот 12 сумын 15 сургуулийн Захирал, Сургалтын менежер, Байгалийн ухааны багш нар болон БСУГ-ын мэргэжилтнүүд"Тогтвортой хөгжлийн боловсрол сургалтанд" хамрагдсан.							

12	Ардчилсан сонгуульд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх нь	Өвөрхангай аймгийн Уянга, Бүрд, Бат-өлзий	ЛЭОС	2016-2017	8,000,000 MNT	Канад сан, Европын холбоо	Улс төр дэх эмэгтэйчүүдийн оролцоог дэмжиж, шийдвэр гаргах түвшинд эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн тэгш байдлыг хангах	Хэрэгжиж байгаа
үр дүн	<b>Гарах үр дүн:</b> 1. Эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог нэмэгдүүлсэн байна. 2. Жендэрийн тэгш байдлыг нийгмийн өргөн хүрээнд бий болгоход эрэгтэйчүүдийн оролцоо, дэмжлэгийг авсан байна.							
13	Иргэддээ ээлтэй баялаг /Мониторинг/	Нарийнтээл сумын Баянтээг уурхай	Орон нутгийн санаачлаг	2017.08-2018.01	3,785,400 MNT	Нээлттэй нийгэм форум	Өвөрхангай аймгийн Нарийнтээл сумын захиргаанаас Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлийн дагуу Баянтээг ХХК-тай байгуулсан Хамтран ажиллах гэрээнд мониторинг хийх	Хэрэгжиж байгаа
үр дүн	<b>Гарах үр дүн:</b> 1. Гэрээ, түүний хэрэгжилтийг сайжруулахтай холбоотой тодорхой санал зөвлөмж гарсан байна. 2. Мониторингийн хүрээнд гарсан санал дүгнэлтийг орон нутгийн иргэд болон гэрээний талуудад хүргэх нөлөөллийн үйл ажиллагаа хийснээр гэрээний чанар, үр нөлөө, хэрэгжилт сайжирсан байна. 3. Мониторингийн хүрээнд сонгон авсан орон нутгийн гэрээний хэрэгжилтийн бодит байдал, түүнд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлсон байна.							
14	Олон нийтийн цагдаа /Мониторинг/	Арвайхээр сумын 11 баг, Уянга сум	ЛЭОС	2017.08-2018.01	3,219,400 MNT	Нээлттэй нийгэм форум	Арвайхээр, Уянга суманд ажиллаж байгаа олон нийтийн цагдаад мониторинг хийх	Хэрэгжиж байгаа
үр дүн	<b>Гарах үр дүн:</b> 1. Мониторингийн хүрээнд гарсан санал дүгнэлтийг орон нутгийн иргэдэд хүргэх нөлөөллийн үйл ажиллагаа хийснээр олон нийтийн цагдаа нарын ажлын чанар, үр нөлөө, хэрэгжилт сайжирсан байна. 2. Мониторингийн хүрээнд сонгон авсан орон нутгийн бодит байдал, түүнд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлсон байна.							
15	"Итгэл найдвар ирээдүй" төсөл	Өвөрхангай аймгийн Арвайхээр сум	Өрхийн тариалан бизнес хөгжлийн төв ТББ	2017-2018	11,142,06 AUD 20,000,000 MNT	Австрали Улсын Элчин сайдын яам	Уг төслөөр Өвөрхангай аймгийн өрх тэргүүлсэн 25 эмэгтэйчүүдийг ногоо тарихад нь тусалж, тогтвортой амьжиргаа, хүнсний аюулгүй байдалд дэмжлэг үзүүлнэ.	Хэрэгжиж байгаа
үр дүн	Уг төслөөр өрх тэргүүлсэн 25 эмэгтэйчүүдийг ногоо тарихад нь тусалж, тогтвортой амьжиргаа, хүнсний аюулгүй байдалд дэмжлэг үзүүлнэ. Арвайхээр сумын өрх толгойлсон 25 эмэгтэй дайргын голд 2 га газарт хүнсний ногоо, нарийн ногоо тариалалт эхэлсэн.							



